



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/511

Арвайхээр

### Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийн 3.5.1.3, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төсвийн ерөнхийлөн захирагч болон Өвөрхангай аймгийн Засаг даргын хооронд хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээний 3.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 03/03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 1.7.3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд төрийн болон нийгмийн анхан шатны үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор төрийн байгууллага болон үйлчилгээний байгууллагуудад дэд бүтэц болон орчны хүртээмжийн үнэлгээ хийхэд 462,500 (дөрвөн зуун жаран хоёр мянга таван зуу) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээнд шаардагдах 462,500 (дөрвөн зуун жаран хоёр мянга таван зуу) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101080